



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2026/001/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойр хот
2026 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 7054-3179

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 7054-3179

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат

Утас: 7054-3179

Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АЗДНС	Аймгийн Засаг даргын нөөц сан
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviusumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
Т.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2026.04.20 № 59
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудад дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

1. Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан 32 байгууллагын нийт зөрчил 1,768.1 сая төгрөг бөгөөд гол зөрчил болох Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангууд материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй илэрхийлэгдсэн, "Энхтүсдэм" өрхийн эрүүл мэндийн төв нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийгдээгүй тайланг нэгтгэсэн, санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн баталгаажаагүй 1,046.4 сая төгрөг нь бидний тогтоосон 480.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ

4226050264

санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.9.4, 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Гол үндэслэл нь MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”: 6 төрийн аудитын зарчим, 6.4.3.1.3 Санал дүгнэлт, 6.4.3.1.3.1 Хязгаарлалттай - Аудитор шалгах зүйлд багтсан материаллаг боловч өргөн тархаагүй тодорхой зүйлийн талаар хангалттай ба зохистой нотлох зүйл олж авах боломжгүй эсвэл зөвшөөрөхгүй байгаа нөхцөлтэй санал нийлэхгүй үед, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/66 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан АДБОУС 200 “Санхүүгийн аудитын зарчим” стандартын 64-т Аудитор нь дараах гурван төрлийн өөрчлөлттэй санал дүгнэлтийг гаргаж болно: хязгаарлалттай санал дүгнэлт - аудитор буруу илэрхийлэл дангаараа эсхүл нийлээд материаллаг боловч өргөн тархаагүй, эсхүл байж болзошгүй буруу илэрхийллийн талаар хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй гэж дүгнэсэн үед, 78-т Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж буй аудитор нь санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлж бэлтгэсэн эсэхэд санал дүгнэлт өгөхийн тулд түүний бүрэлдэхүүн тайлангуудын санхүүгийн мэдээлэл, нэгтгэлийн үйл явцын найдвартай байдлын талаар хангалттай, зохистой аудитын нотолгоог бүрдүүлэх шаардлагатай гэж заасан.

Асуудлыг онцолсон хэсэг

Говьсүмбэр аймгийн Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль тогтоомж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллажээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын ашигт ажиллагаа буурч байгууллагын хэвийн үйл ажиллагаанд эрсдэл үүссэн байна. Тайлант хугацаанд УСДУ ОНӨААТҮГ УБТЗХНН-ийн Чойр хэсгийн 1, 2, 3 дугаар уурын зуухыг аймгийн ИТХ-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор хүлээн авсан байна. Хүлээн авсан уурын зуухнууд ашиглалтын шаардлага хангаагүйгээс урсгал засварын зардал нэмэгдсэн, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс цалин хөлс, нүүрс, тээвэр шатахуун, гэрэл цахилгааны зардлууд нэмэгдэж, жилийн эцсийн байдлаар 1,185.5 сая төгрөгийн

өр төлбөр тайлагнажээ. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудын хэвийн үйл ажиллагааг хангахад анхаарах шаардлага үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан бөгөөд АИТХ-ын хуралдааны 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 85.1 хувийн биелэлттэй буюу үр дүнтэй гэж үнэлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2025 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		21,225,193.56	21,914,541.31
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	14,251,566.61	11,765,748.24
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,285,698.9	2,411,820.69
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	32,196.67	7,054.38
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	4,208,511.14	3,304,748.72
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	106,367.5	158,698.5
7	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	1,340,852.73	4,266,470.78
8	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		43,615,159.17	49,324,992.74
9	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	43,615,159.17	49,324,992.74
10	1.2.2.02 Биет хөрөнгө		33,198,976.03	38,136,567.57
11	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	10,416,183.14	11,188,425.18
12	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		64,840,352.72	71,239,534.05
13	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		24,395,588.58	23,846,214.78
14	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		5,201,661.96	3,275,580.06
15	2.1.1.03 Өглөг		5,201,661.96	3,275,580.06
16	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		19,193,926.63	20,570,634.72
17	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	19,193,926.63	20,570,634.72
18	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		40,444,764.14	47,393,319.28
19	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		40,444,764.14	47,393,319.28
20	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		21,759,785.61	22,409,810.61
21	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		13,471,088.27	19,547,211.24
22	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		5,213,890.26	5,436,297.43
23	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		64,840,352.72	71,239,534.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2025 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		37,249,977.2	40,716,767.14
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		15,288,977.16	19,340,989.84
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		12,236,129.13	15,610,608.22
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		11,954,160.18	15,406,195.92
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-398,030.86	-499,956.98
6	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар		679,999.81	704,369.28
7	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		931,016.47	1,058,410.6
8	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		2,121,831.55	2,671,971.02
9	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	20,462,572.29	21,375,777.3
10	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	1,096,050.86
11	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,498,427.75	0.0
12	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	32,037,961.09	34,821,842.87
13	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		32,037,961.09	34,084,713.8
14	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		30,111,350.24	32,201,682.67
15	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		7,004,609.88	8,930,097.7
16	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		827,924.31	1,033,262.83
17	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,576,656.43	4,921,991.38
18	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		7,603,888.06	7,386,238.52
19	1.1.2.01.1.05 Нормативт зардал		172,371.88	136,791.32
20	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		359,859.08	391,676.35
21	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		262,511.24	169,556.79
22	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,637,639.38	4,694,584.39
23	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		5,665,889.98	4,537,483.4
24	1.1.2.01.3 ТАТААС		0.0	2,200
25	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,926,610.85	1,880,831.13
26	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	737,129.07
27	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		5,212,016.11	5,894,924.27
28	1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		17,685.39	45,389.68
29	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		264,892.46	54,746.03
30	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-247,207.07	-9,356.35
31	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		4,964,809.04	5,885,567.92

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,623,789.66		30,623,789.66
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	62,079.93		62,079.93
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,685,869.59		30,685,869.59
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-63,419.36		-63,419.36
5	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,857,504.88		4,857,504.88
6	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	4,964,809.04		4,964,809.04
7	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	40,444,764.14		40,444,764.14
8	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	40,444,764.14		40,444,764.14
9	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	235,944.73		235,944.73
10	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	40,680,708.87		40,680,708.87
11	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	290,491.67		290,491.67
12	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	350,025		350,025
13	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	186,525.82		186,525.82
14	1.7 Тайлант үеийн үр дүн	5,885,567.92		5,885,567.92
15	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	47,393,319.28		47,393,319.28

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2025 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	41,593,847.42	40,730,863.49
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	15,288,977.16	19,340,989.84
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	12,236,129.13	15,610,608.22
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-398,030.86	-499,956.98
5	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	679,999.81	704,369.28
6	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	931,016.47	1,058,410.6
7	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	2,121,831.55	2,671,971.02
8	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	423,630.36	458,269.11
9	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	1,177,527.61	1,924,029.69
10	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	520,673.58	289,672.22
11	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,814,952.14	21,389,873.65
12	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	11,237,866.04	9,363,354.59
13	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,140,196.16
14	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	13,577,086.1	10,886,322.9
15	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,489,918.12	0.0
16	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,060,393.04	32,634,554.85
17	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	27,060,393.04	32,634,554.85
18	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,935,558.26	30,969,897.54
19	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,016,247.38	11,814,506.09
20	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,346,080.85	1,039,705.22
21	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,099,324	5,443,863.69
22	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	1,761,113.36	1,971,847.98
23	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	76,941.49	76,158.18
24	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	448,573.08	458,514.48
25	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	262,931.24	168,470.69
26	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,991,992.38	3,737,293.58
27	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	4,932,354.48	6,259,537.63
28	1.1.1.2.01.3 ТАТААС	0.0	2,200
29	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,124,834.78	1,662,457.31
30	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,533,454.38	8,096,308.64
31	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	9,275,401.98	10,050,371.51
32	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,275,401.98	10,050,371.51
33	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	9,275,401.98	10,050,371.51
34	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-9,275,401.98	-10,050,371.51
35	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,782.36	531,755.5
36	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-3,782.36	-531,755.5
37	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	5,254,270.04	-2,485,818.37
38	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,997,296.57	14,251,566.61
39	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,251,566.61	11,765,748.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	30,087,101.5	32,508,471.5
2	3.1.01.1.1 Татварын орлого	16,730,054.4	19,340,989.84
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	13,320,791.3	15,610,608.22
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	13,190,791.3	15,406,195.92
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	11,780,791.3	14,022,995.04
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	100,000	151,110.83
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	590,000	426,952.97
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	290,000	247,521.63
9	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	430,000	557,615.45
10	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-500,000	-499,956.98
11	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-500,000	-499,956.98
12	3.1.01.1.1.1.4 ААН-ын орлогын албан татвар	630,000	704,369.28
13	3.1.01.1.1.1.4.01 ААН-ын орлогын албан татвар	630,000	704,369.28
14	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	938,800	1,058,410.6
15	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	746,000	778,394.89
16	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	6,800	6,131
17	3.1.01.1.1.3.3 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	166,000	165,261.01
18	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	20,000	108,623.7
19	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	2,470,463.1	2,671,971.02
20	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	367,000	458,269.11
21	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	80,000	141,444.61
22	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	37,000	44,095.85
23	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	250,000	272,728.64
24	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	1,399,389.4	1,924,029.69
25	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	526,000	977,872.84
26	3.1.01.1.1.8.2.02 Дуудлага худалдаа	873,389.4	946,156.85
27	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	704,073.7	289,672.22
28	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	54,073.7	83,313.21
29	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	650,000	206,359.01
30	3.1.01.1.2 Татварын бус орлого	13,357,047.1	13,167,481.66
31	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	2,407,656.7	2,281,158.76
32	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	1,820,000	1,667,644.69
33	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	358,137.5	292,892.72
34	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	39,219.2	44,052.74
35	3.1.01.1.2.1.6 Түрээсийн орлого	190,300	172,895.06
36	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	0.0	103,673.55
37	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	10,949,390.4	10,886,322.9
38	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	5,829,689.5	5,766,622
39	3.1.01.1.2.4.3 Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	5,119,700.9	5,119,700.9

40	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,064,828.8	31,315,991.74
41	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	24,386,355.8	21,684,031.63
42	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,051,956.9	20,038,200.49
43	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,635,350.7	8,199,450.71
44	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	3,665,492.9	3,870,553.85
45	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	3,683,971.4	3,235,629.62
46	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	647,088.1	606,078.84
47	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	615,953	465,319.59
48	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	22,845.3	21,868.82
49	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,045,028.3	952,811.71
50	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	691,879	656,340.98
51	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	88,213.6	78,138.58
52	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	62,524.9	44,138.98
53	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	26,438.3	32,733.38
54	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	175,972.5	141,459.77
55	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,212,539.8	4,880,852.98
56	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	526,135.4	490,070.56
57	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	4,044,462.7	3,852,808.89
58	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	641,941.7	537,973.53
59	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	336,461.7	261,396.27
60	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	59,886.9	44,082.25
61	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	159,460	131,492.33
62	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,844.8	29,625.47
63	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,360	1,997
64	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,910	54,199.22
65	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	4,857	4,057
66	3.1.01.2.1.1.5.01 Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	207	207
67	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,650	3,850
68	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	559,113.6	487,575.38
69	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	106,186	65,169.1
70	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,800	1,824
71	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	447,127.6	420,582.28
72	3.1.01.2.1.1.7 Томиллолт, зочны зардал	188,411	165,128.69
73	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томиллолт	183,405	162,079
74	3.1.01.2.1.1.7.03 Зочин төлөөлөгч хүлээн авах	5,006	3,049.69
75	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,561,769	2,352,059.34
76	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,514,486.7	2,316,496.26
77	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,062	1,062
78	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	17,538	13,893.01
79	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	2,794.2	1,799.11
80	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,136.2	894.98
81	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,530	12,323.6
82	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	9,221.9	5,590.39
83	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	3,508,425.8	2,734,868.41

84	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	3,464,150.8	2,712,507.91
85	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,275	22,360.5
86	3.1.01.2.1.3 ТАТААС	25,000	2,200
87	3.1.01.2.1.3.1 Төрийн өмчит байгууллагад олгох татаас	25,000	2,200
88	3.1.01.2.1.3.1.01 Төрийн өмчит байгууллагад олгох татаас	25,000	2,200
89	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,309,398.9	1,643,631.14
90	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,773,747.8	1,382,941.46
91	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,773,747.8	1,382,941.46
92	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	535,651.1	260,689.68
93	3.1.01.2.1.4.2.02 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	40,750	14,625
94	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	150,000	55,816.8
95	3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	135,493.6	69,449.3
96	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	70,707.5	59,270.28
97	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	138,700	61,528.3
98	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,470,068.3	9,100,204.61
99	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	13,470,068.3	9,100,204.61
100	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,208,404.7	531,755.5
101	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	1,208,404.7	531,755.5
102	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-8,977,727.3	1,192,479.76
103	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,977,727.3	-1,192,479.76
104	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	8,977,727.3	-1,192,479.76
105	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	9,038,727.79
106	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	10,231,207.56
107	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	474	495
108	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	16	16
109	6.1.01 Төсвийн байгууллага	16	16
110	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	229	262
111	6.2.01 Удирдах ажилтан	44	44
112	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	135	166
113	6.2.03 Үйлчлэх ажилтан	43	46
114	6.2.04 Гэрээт ажилтан	7	5
115	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	229	216
116	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	104	91
117	6.5.02 Төрийн тусгай албан хаагч (ТТ)	2	2
118	6.5.06 Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	3	2
119	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	90	91
120	6.5.10 Гэрээт ажилтан	6	4
121	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	24	25
122	6.5.14 Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	0.0	1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	150,901.01
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	150,901.01
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	150,901.01
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	150,901.01
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	150,901.01
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,643.76
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,622.08
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,635.16
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	203,416.66
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	203,416.66
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	203,416.66
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	41,841.85
210101	1.1.1.2.1.1.1.1 Үндсэн цалин	26,201.66
210102	1.1.1.2.1.1.1.2 Нэмэгдэл	6,260.19
210103	1.1.1.2.1.1.1.3 Унаа хоолны хөнгөлөлт	9,380.00
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,274.34
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	5,274.34
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	662.32
210301	1.1.1.2.1.1.3.1 Гэрэл, цахилгаан	662.32
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	9,757.00
210401	1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	57.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	8,860.00
210406	1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	840.00
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	1,179.20
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	1,179.20
2107	1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал	800.00
210702	1.1.1.2.1.1.7.2 Дотоод албан томилолт	800.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,931.19
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,931.19
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	115,970.77
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	115,970.77
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(52,515.66)
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,515.66
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	52,515.66
9	2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	84,554.01

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Засаг дарга нь эрхэм зорилгоо “Хүний хөгжилд суурилсан эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж, олон улсын чанарт нийцсэн төрийн үйлчилгээг иргэдэд мэргэжлийн түвшинд, ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэж, тасралтгүй хөгжсөн байгууллага байх” гэж тодорхойлжээ.

Говьсүмбэр аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл:

1. Уул уурхай
2. Тээвэр логистик
3. Хөдөө аж ахуй
4. Аялал жуулчлал

Стратегийн зорилго

1. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүний хөгжлийн бодлогыг дэмжиж, шинжлэх ухаан, инновацид тулгуурлан эрүүл мэнд, боловсрол, соёл, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх

2. Эдийн засгийн бодлогын хүрээнд:

Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, инновацыг нутагшуулах замаар нэмүү өртөг шингэсэн уул уурхайн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, газар нутгийн байршил, зам тээвэр, харилцаа, холбоо, дэд бүтцийн давуу байдалд түшиглэсэн тээвэр, логистикийн нөөцөд тулгуурлан олон тулгуурт эдийн засгийн өсөлтийг хангах

3. Засаглалын бодлогын хүрээнд:

Тогтвортой, нэгдмэл гадаад, дотоод бодлогын хүрээнд төр, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаанд тулгуурлан хүний эрх, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлж, гамшиг, осол, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог хэрэгжүүлэх замаар иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх

4. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд: Байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлтийг хангахуйц байгаль орчинд ээлтэй шинжлэх ухаан, инноваци, дэвшилтэт технологийг дэмжих замаар уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлоос хамгаалж, иргэдийн эрүүл орчинд амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан бөгөөд АИТХ-ын хуралдааны 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 85.1 хувийн биелэлттэй буюу үр дүнтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
3. тухай хууль
4. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай хууль
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль
6. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
7. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль

ТЕЗ-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт дунд гэж үнэлсэн байна.

Тайлант жилийн дундуур ТЕЗ-ийн ерөнхий санхүүч болон төсвийн мэргэжилтэн нар солигдсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,399.1 сая төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,251.5	11,765.8	-2,485.8
Авлага	1,285.7	2,411.8	1,126.1
Урьдчилгаа	32.2	7.1	-25.2
Бараа материал	4,208.5	3,304.8	-903.8
Нөөцийн бараа	106.4	158.7	52.3
Бусад эргэлтийн хөрөнгө	1,340.9	4,266.5	2,925.6
Үндсэн хөрөнгө	43,615.2	49,325.0	5,709.8
Нийт хөрөнгө	64,840.4	71,239.5	6,399.1
Өр төлбөр	24,395.6	23,846.2	-549.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	40,444.8	47,393.3	6,948.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	64,840.4	71,239.5	6,399.1

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл **11,765.7** сая төгрөг болж, өмнөх оноос **2,485.8** сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	(сая төгрөгөөр)
			Өсөлт (+), Бууралт (-)

1 МӨНГӨН ХӨРӨНГӨ ДҮН	14,251.6	11,765.7	(2,485.8)
1.1 Кассад байгаа бэлэн мөнгө	13.6	8.3	(5.3)
1.1.1 Төгрөг	13.6	8.3	(5.3)
1.2 Банкинд байгаа бэлэн мөнгө	14,237.9	11,757.5	(2,480.5)
1.2.1 Төгрөг	14,237.9	11,757.5	(2,480.5)
1.2.1.1 Төрийн сангийн харилцах	14,162.0	11,348.3	(2,813.7)
1.2.1.3 Арилжааны банк дахь харилцах	75.9	409.1	333.2
Дүн	14,251.6	11,765.7	(2,485.8)

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Кассад байгаа бэлэн мөнгө: “Ус-Ду” ОНӨААТҮГ 8.3 сая төгрөгийн кассын үлдэгдэлтэй байна.

Банкинд байгаа бэлэн мөнгө: Төрийн сангийн харилцах 11,348.3 сая, арилжааны банкны харилцах 409.1 сая төгрөгийн үлдэгдлээс бүрдэж байна.

- **Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 11,348.3 сая төгрөгийг сумдаар харуулбал:**

Хүснэгт №3 (сая төгрөгөөр)

Сум/Аймаг	Хоршоо хөгжүүлэх сан	ОНХС	Барьцаа	Ерөнхий орлого	Ахмадын сан	Нийт
Сүмбэр	592.3	648.2	140.3	471.7	10.1	1,862.6
Шивээговь	37.3	372.7	31.7	1,927.5	11.6	2,380.8
Баянтал	22.9	104.5	41.8	413.6	7.8	590.6
Аймаг		886.7	849.2	4,753.8	24.6	6,514.3
Нийт	652.5	2,012.1	1,063.0	7,566.6	54.1	11,348.3

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

- **Арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэл 75.9 сая төгрөгийг байгууллагаар нь харуулбал:**

Хүснэгт №4 (сая төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	Дансны үлдэгдэл
1	Гс. Ахмадын хороо - 1009095	47.3
2	Талын-Илч - 2005166	2.5
3	Ус-Ду - 2004933	13.6
4	Тохижилт Сүмбэр - 2005093	298.4
5	Илчлэг-Шивээ - 2005123	4.2
6	Гс. Сү.Өрхийн эмнэлэг - 2005344	43.1
	Нийт	409.1

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Нийт мөнгөн хөрөнгийн 96.4 хувь төрийн сангийн харилцах дансанд, 3.5 хувь арилжааны банкинд 0.1 хувь нь кассат байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2,485.8 сая төгрөг буюу 17.4 хувиар буурсан байна. Үүнд аймаг, Сүмбэр, Шивээговь сумын барьцаа хөрөнгийн данс 3,865.7 сая, байгууллагуудын ахмадын сангийн дансны үлдэгдэл 54.6 сая төгрөгөөр тус тус буурч, ОНХС-гийн дансны үлдэгдэл 651.6 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын мөнгөн хөрөнгийн данстай холбоотой 406.0 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Үүнд:

1. Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ нь санхүүгийн байдлын тайлан дахь мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 406.0 сая төгрөгийг харилцагч банкуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 2,411.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,126.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	4.8	177.1	172.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	38.4	9.8	-28.6
Зээлийн хүүгийн авлага	40.4	62.4	22.0
Дансны авлага /ТӨҮГ/	19	10.1	-8.9
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	1.5	5.7	4.2
Байгууллагаас авах авлага	696.6	1,852.2	1,155.6
Хувь хүмүүсээс авах авлага	484.9	294.5	-190.4
Дүн	1,285.60	2,411.8	1,126.2

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Ажиллагсадтай холбоотой авлага: өмнөх оноос авлага 172.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд ЦСҮТ ОНӨҮГ-ыг татан буулгахтай холбоотой тооллогоор дутагдсан хөрөнгийн дүн 170.4 сая төгрөгөөр авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Төлбөртэй үйлчилгээний авлага: 28.6 сая төгрөгөөр буурсан нь Энх тус дэм ӨЭМТ-ийн авлага буурсантай холбоотой байна.

Зээлийн хүүгийн авлага: өмнөх оноос 22.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Баянтал сумын хоршоо хөгжүүлэх сангийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дансны авлага өмнөх оноос 8.9 сая төгрөгөөр буурсан нь Талын илч ОНӨААТҮГ-ын айл өрхөөс авах дулааны авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Татвар, НДШ-ийн авлага: өмнөх оноос 4.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Илчлэг шивээ ОНӨААТҮГ-ын авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Байгууллагаас авах авлага: 1,155.6 сая төгрөгөөр нэмэгдэж 1,852.2 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Үүнд: УСДУ ОНӨААТҮГ-ын авлага 702.3 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 2025 онд УБТЗХНН-ээс Ганзам багийн халаалтын уурын зуухыг хүлээн авсан, 2025 онд гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт олгогдоогүйтэй холбоотойгоор авлага нэмэгдсэн, Барьцаа данснаас Хан атрибут ХХК-д илүү олгосон гүйцэтгэлийн санхүүжилтийн авлага 212.9 сая, Сангийн яамнаас 76.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг барьцаа данснаас илүү татан төвлөрүүлсэн тул тус тус авлага үүсгэсэн, Шивээговь, Баянтал сумын хоршоо хөгжүүлэх сангаас 200.0 сая төгрөгийн зээл олголт хийсэнтэй холбоотой авлага нэмэгдсэн байна.

Хувь хүмүүсээс авах авлага: 190.4 сая төгрөгөөр буурч 294.5 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан. Үүнд: Сүмбэр сумын хоршоо хөгжүүлэх сангийн авлага 141.9 сая төгрөгөөр нэмэгдэж, Баянтал сумын ИТХ, хоршоо хөгжүүлэх сан, Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн авлага 82.7 буурсантай холбоотой байна.

Авлагын насжилтыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №6

(сая төгрөгөөр)

Авлагын насжилт					
0-1 жил	1-2 жил	2-3 жил	3-4 жил	4-5 жил	5-аас дээш жил
1,141.6	882.0	71.2	222.0	11.6	83.3
47.3%	36.6%	3%	9.2%	0.4%	3.5%

0-1 жил болсон авлага: 1,141.6 сая

- 1 Аймгийн барьцаа дансны авлага-289.8 сая
- 2 Талын илч, Илчлэг шивээ, ЦСҮТ-ийн ОНӨААТҮГ-дын авлага-256.1 сая
- 3 Сүмбэр, Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн авлага-562.5 сая
- 4 Энхтүсдэм ӨЭМТ-ийн авлага-15.8 сая
- 5 Төрийн байгууллагуудын авлага-17.2 сая /Сүмбэр ИТХ-0.1 сая, Баянтал ЗДТГ-0.2 сая, Сүмбэр ЗДТГ-4.3 сая, ОНӨГ-0.3 сая, Шивээговь ИТХ-0.3 сая, Аймгийн ЗДТГ-11.7 сая,

ИТХ-0.3 сая/

1-2 жил жил болсон авлага: 882.0 сая

1. УСДУ ОНӨААТҮГ-850.0 сая /үйлчилгээний авлага, хөрөнгө оруулалтын авлага/
2. Шивээговь ЗДТГ-31.9 сая /ажлаас хууль бусаар чөлөөлөгдсөн албан хаагчид олгосон/

2-3 жил болсон авлага: 71.2 сая

1. Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн авлага-71.2 сая

3-4 жил болсон авлага: 222.0 сая

1. Баянтал сумын хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага-222.0 сая

4-5 жил болсон авлага: 11.6 сая

1. Баянтал сумын ОНХС-гийн авлага-9.5 сая
2. Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн авлага-2.1 сая

5-аас дээш жил болсон авлага: 83.3 сая

1. Баянтал сумын ЗДТГ-3.3 сая /эзэн холбогдогч тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага/
2. Аймгийн ОНХС-47.3 сая /Магнус солус авто зогсоол/
3. Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн авлага-2.6 сая
4. Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-29.9 сая

Нийт бүртгэсэн авлагыг насжилтаар нь авч үзэхэд төлөгдөх хугацаа хэтэрсэн авлага 16.1 хувийг эзэлж байна. Төсөв захирагчид төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар идэвх санаачлага гаргаагүй, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахгүй байна. Иймд аймгийн ТЕЗ буюу Засаг даргын зүгээс ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд хугацаа хэтэрсэн авлагын барагдуулалтыг оруулж дүгнэх, төсөв захирагч бүр төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас Авлагын данстай холбоотой 77.8 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 4.1 сая төгрөгийн 3 албан шаардлага, 11.6 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

1. Аймгийн ЗДТГ, Сүмбэр сумын ИТХ, Баянтал, Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн авлагын бүртгэл тайлагналтай холбоотой 77.8 сая төгрөгийн 4 алдааг залруулсан.
2. Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн 8.3 сая төгрөгийн авлагыг төлүүлэх, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх албан шаардлага өгсөн.
3. Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын авлагын бүртгэл НББ-ийн хууль тогтоомжид нийцээгүй тул зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 7.0 сая төгрөг болж, өмнөх оноос 25.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Урьдчилгаа дансны үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	-	6.5	6.5
Төсөвт байгууллага	15.6		(15.6)
Урьдчилгаа тооцоо	16.5	6.5	(10.0)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.0	-	(1.0)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	15.0	-	15.0
Цалингийн урьдчилгаа	0.5	0.5	-
Дүн	32.1	7.0	- 25.1

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Урьдчилгаа данс буурсан шалтгаан: Аймгийн төсвийн орлогод аймгийн ЗДТГ-ын цэргийн дүйцүүлэх мөнгөн орлогоос 15.6 сая төгрөгийг төвлөрүүлж авлага үүсгэн бүртгэсэн бөгөөд тайлант хугацаанд авлагыг барагдуулсан мөн авто замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн /замын тэмдэг тэмдэглэгээ, нар салхины эх үүсвэрээр ажилладаг гэрэлтүүлэг/ боловч улсын комисс томилж хүлээн аваагүй, санхүүжилт олгосон дүнгээр авлагад бүртгэсэн байсан 16.5 сая төгрөгийн ажлыг төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу ажлын хэсэг байгуулан тухайн үеийн гүйцэтгэлийг дахин хянаж ажлыг хүлээн авсантай холбоотой байна. Харин Байгаль орчны газар 6.5 сая төгрөгийг урьдчилж гарсан зардалд бүртгэсэн нь Чойрын богд уулын байгаль орчны менежментийн төлөвлөгөө хийлгэх ажлын санхүүжилтэд урьдчилгаа төлбөр төлсөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Урьдчилгаа данстай холбоотой ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас алдаа, зөрчил илрээгүй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 3,304.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1,114.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Бараа материалын үлдэгдэл (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	244.9	165.6	(79.3)
Тусгай зориулалттай материал	175.4	133.5	(41.9)
Эм боох материал	69.6	32.1	(37.5)
Дуусаагүй үйлдвэрлэл			-
Бэлэн бүтээгдэхүүн			-
Хангамжийн материал	3,963.6	3,031.1	(932.5)
Бичиг хэргийн материал	25.3	22.4	(2.9)
Аж ахуйн материал	528.7	857.0	328.3
Сэлбэг хэрэгсэл	18.3	22.6	4.3
Түлш, шатах тослох материал	13.4	18.1	4.7
Барилгын засварын материал	11.9	12.7	0.8
Хүнсний материал			-
Бусад хангамжийн материал	3,155.0	2,098.3	(1,056.7)
Мал амьтад	210.9	108.0	(102.9)
Дүн	4,208.5	3,304.7	(1,114.7)

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Бараа материал дансны эхний үлдэгдэл 4,208.5 сая төгрөг байсан ба тайлант хугацаанд худалдан авсан 1,302.7 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 993.1 сая, нийт 2,295.8 сая төгрөгөөр нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд 1,647.3 сая төгрөгийг зарцуулж, 1,552.2 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, акталж устган нийт 3,199.5 сая төгрөгөөр буурч 3,304.7 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Акталж устгасан бараа материалын дүн өсөхөд Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар 2025.11.14-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар 1,007.6 сая төгрөгийн бараа материалыг данснаас хассан нь нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас Бараа материал данстай холбоотой нийт 6.9 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 2.0 сая төгрөгийн 2 зөвлөмж, 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

- Сум дундын ойн анги:** Бусад хангамжийн материалын тайланд 6.9 сая төгрөгийн 2 гүйлгээг анхан шатны баримтад үндэслэн бүртгээгүй. Түлш шатахууны тайланд 73.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг сөрөг үлдэгдэлтэй тайлагнасан тул залруулсан.
- Аймгийн ЗДТГ:** 2.0 сая төгрөгийн бараа материалын зарцуулалт анхан шатны баримтын бүрдэл хангаагүй.

3. **Худалдан авах ажиллагааны газар:** Тооллогын үр дүнгээр тооцоо бодож, акт үйлдэж баталгаажуулаагүй тул зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.
4. **Шивээговь сумын ЗДТГ:** Тээвэр шатахууны зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулж, сумаас аймаг, аймгаас сум хүртэлх зайг 3009 км-ээр хэтрүүлж тооцон шатахуун олгосон тул 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

3.4.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны эцсийн үлдэгдэл 158.7 сая төгрөг болж, өмнөх оноос 52.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. Нөөцийн бараа үлдэгдэл (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	106.4	158.7	52.3
Дүн	106.4	158.7	52.3

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 52.3 сая төгрөгөөр нэмэгдэхэд Сүмбэр сумын ЗДТГ 47.0 сая төгрөгийн өвс тэжээлийг сумын ОНХС-гаас хүлээн авч бүртгэсэн нь гол нөлөө үзүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

Нөөцийн бараа данстай холбоотой ТЕЗ-ийн харьяа байгууллагуудаас алдаа, зөрчил илрээгүй байна.

3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 4,266.5 сая төгрөг болж, өмнөх оноос 2,925.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	1,340.8	4,266.5	2,925.7
Дүн	1,340.8	4,266.5	2,925.7

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл: Аймгийн ОНХС-гийн 10 төсөл, арга хэмжээний 564.3 сая, ОНТХО-ын 8 төсөл, арга хэмжээний 834.0 сая, Шивээговь сумын ОНХС-гийн 3 төсөл, арга хэмжээний 1,442.1 сая, Авто замын сангийн 3 төсөл, арга хэмжээний 433.4 сая, Сүмбэр сумын ОНХС-гийн 2 төсөл, арга хэмжээний 992.7 сая төгрөгийн ажлуудад олгосон санхүүжилтийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгө данс үлдэгдэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасантай нийцсэн байна.

Аудитын илрүүлэлт

- **Шивээговь сумын ОНХС:** 1 ажил, 3 зураг он дамжин хэрэгжихээр болсон боловч эргэлтийн хөрөнгөд бүртгээгүй тул 1,442.1 сая төгрөгийг журмын дагуу бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгүүлж залруулга хийсэн. /Гэр хорооллын гадна цэвэр ус, гадна бохир усны шугамд холбох ажил, сумын халаалтын зуухны барилгын өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг төсөв, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дэд бүтцийн ажлын зураг төсвийн зардал, нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтын ажлын зураг төсөв/

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 49,325.0 сая төгрөг болж, өмнөх

оноос 5,709.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	33,198.9	38,136.6	4,937.7
Барилга, байгууламж, орон сууц	13,904.0	13,617.6	(286.4)
Авто-тээврийн хэрэгсэл	2,009.1	2,316.8	307.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,670.6	3,584.2	(86.4)
Тавилга, аж ахуйн эд хогшил	499.1	444.7	(54.4)
Зам, гүүрний байгууламж	5,072.3	9,880.1	4,807.8
Бусад үндсэн хөрөнгө	8,028.8	8,266.2	237.4
Дуусаагүй барилга, байгууламж	15.0	27.0	12.0
Биет бус хөрөнгө	10,416.2	11,188.4	772.2
Программ хангамж	47.4	27.8	(19.6)
Бусад биет бус хөрөнгө	10,368.8	11,160.6	791.8
Дүн	43,615.1	49,325.0	5,709.9

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө данс худалдан авсан 299.7 сая, үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн 11,022.7 сая нийт 11,322.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 777.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 535.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 1,120.5 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасч, данснаас хасагдсан хөрөнгөд ногдох үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний хорогдол 119.3 сая нийт 2,552.0 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 5,709.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд дараах өөрчлөлтүүд голлох нөлөө үзүүлжээ. Үүнд:

- УСДУ ОНӨААТҮГ: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 433.2 сая төгрөгийн экскаватор, чиргүүл, арилжааны банкны зээлээр 189.8 сая төгрөгөөр ковш худалдан авсан.
- Баянтал сумын ЗДТГ: Баянтал сумын 3.4 км авто замыг 4,619.0 сая төгрөгөөр бүртгэсэн.
- Сум дундын ойн анги, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ууд нь 600.0 сая төгрөгөөр байгууллагын эзэмшил газрыг бүртгэсэн.

Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 27.0 сая төгрөг нь “Илчлэг-Шивээ” ОНӨААТҮГ-ын зураг төсөв байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн данстай холбоотой 774.0 сая төгрөгийн 10 залруулга хийж зөрчлийг 79.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Ахмадын хороо-1.5 сая, Орон нутгийн өмчийн газар 4.1 сая, Сум дундын ойн анги 56.1 сая, Шивээговь сумын Засаг дарга ТТЗ-172.1 сая, Илчлэг шивээ ОНӨААТҮГ- 15.0 сая, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-333.8 сая, УСДУ ОНӨААТҮГ-189.1 сая, ЦСҮТ-2.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой алдааг аудитын явцад залруулсан.
2. Аймгийн ЗДТГ: Ашиглалтын хугацаа дууссан 172 нэр төрлийн 747.5 сая төгрөгийн хөрөнгийн үнэ, ашиглах жилийг тогтоогоогүй, хөрөнгийг үнэгүйдүүлсэн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.
3. Шивээговь сумын ЗДТГ: Тус байгууллагад 12 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй боловч АТҮТ-д бүртгэлгүй 2, байгууллага, иргэнд ашиглуулж буй 2, эвдэрч ашиглах боломжтой болсон 1 нийт 5 тээврийн хэрэгсэл байгаа тул Авто тээврийн үндэсний төвд 2 тээврийн хэрэгслийг бүртгүүлэх, байгууллага иргэнд ямар нэгэн шийдвэргүй ашиглуулж байгаа тээврийн хэрэгслийг нөхцөл байдлыг судалж шийдвэр гаргах, ашиглах боломжгүй тээврийн хэрэгслийг Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж дүгнэлт гаргах, тухайн байгууллагын дансанд бүртгэлгүй боловч Авто тээврийн үндэсний төвд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг хасуулах талаар зөвлөмж өгсөн.

3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 23,846.1 сая төгрөг болж, өмнөх оноос 549.4 сая

төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 12. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	5,201.6	3,275.5	(1,926.1)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	0.3	0.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	8.6	8.6
Байгууллагад төлөх өглөг	5,121.8	3,056.3	(2,065.5)
Хувь хүмүүст төлөх өглөг	3.9	27.2	23.3
Татвар, НДШ-ийн өглөг	70.7	183.1	112.4
Урьдчилж орсон орлого	5.2		(5.2)
Урт хугацаат өр төлбөр дүн	19,193.9	20,570.6	1,376.7
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	19,193.9	20,570.6	1,376.7
Нийт дүн	24,395.5	23,846.1	(549.4)

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Нийт богино хугацаат өр төлбөрийн **41 хувь буюу 1,352.8 сая** төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа, **36 хувь буюу 1,185.5 сая** төгрөгийг **УСДУ ОНӨААТҮГ**-ын нүүрс 615.0 сая, Нийгмийн даатгалын шимтгэлийн өр 130.0, ХХОАТ-ын өр 97.0 сая, БЗӨБЦТС ХК-д цахилгааны өр 103.0 сая, банкны зээлийн өр 115.0 сая, бусад байгууллагад төлөх өр төлбөр 125.5 сая төгрөг байна.

Богино хугацаат өр төлбөрийг насжилтаар нь харуулбал:

Хүснэгт №13

(сая төгрөгөөр)

0-30 хоног	30-180 хоног	180-аас дээш хоног
267.3	9.8	2,998.4
8.2%	0.3%	91.5%

Нийт богино хугацаат өр төлбөрийн 8.2 хувь 0-30 хоног, 0.3 хувь нь 30-180 хоног, 91.5 хувь нь 180-аас дээш хоногийн насжилттай байна. 180-аас дээш хоногийн насжилттай өр төлбөрийг барьцаа данс эзэлж байна.

Харин урт хугацаат өр төлбөр 20,570.6 сая төгрөг нь ОНӨААТҮГ-д улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй олгосон үндсэн хөрөнгийг хойшлуулсан өр төлбөрөөр бүртгэсэнтэй **холбоотой** байна.

- ✓ **Ажиллагсадтай холбоотой өр төлбөр:** Сүмбэр сумын ИТХ-0.1 сая, ОНӨГ-0.2 сая
- ✓ **Бараа үйлчилгээний зардлын өр төлбөр:** Байгаль орчныг хамгаалах газар, Сүмбэр сумын ЗДТГ, Сум дундын ойн анги, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба, Шивээговь сумын ИТХ, Шивээговь сумын соёлын төв нь зарцуулах эрх хааснаас шалтгаалан 8.6 сая төгрөгийн өр төлбөр тайлагнасан.
- ✓ **Байгууллагад төлөх өр төлбөр:** Өмнөх оноос 2,065.5 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 3,575.6 сая төгрөгөөр буурч УСДУ ОНӨААТҮГ-ийн өр 1,001.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагад төлөх өр төлбөр нэмэгдэхэд голлох нөлөө үзүүлсэн байна.
- ✓ **Татварын НДШ-ийн өр:** Өмнөх оноос 112.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Талын илч ОНӨААТҮГ-ын өр 15.6 сая, УСДУ ОНӨААТҮГ-ын өр 76.7 сая, Илчлэг шивээ ОНӨААТҮГ-ын өр 20.2 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.
- ✓ **Хойшлогдсон өр төлбөр:** Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3,180.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэж хуримтлагдсан элэгдлийн зардал 1,803.4 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

Өр төлбөр холбоотой нийт 0.4 сая төгрөгийн 1 алдаа, 1.6 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлсэн. Үүнд:

1. Шивээговь сумын ЗДТГ: Ерөнхий журналд 0.4 сая төгрөгийн цалингийн зардлыг бууруулах бичилт хийж, өр төлбөрийг дутуу тайлагнасан тул аудитын явцад залруулсан.

- Илчлэг шивээ ОНӨААТҮГ: 6 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан боловч цалингаас хийсэн суутгалыг 0.5 сая төгрөгөөр илүү тооцож суутгасан.
- Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ: Төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг хойшлогдсон өр төлбөрөөр бүртгээгүй.

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 47,393.3 сая төгрөг болж, өмнөх оноос 6,948.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 14. Засгийн газрын хувь оролцоо

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,759.8	22,409.8	650.0
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	21,759.8	22,409.8	650.0
Хуримтлагдсан үр дүн	13,471.1	19,547.1	6,076.0
Өмнөх үеийн үр дүн	8,506.3	13,661.6	5,155.3
Тайлант үеийн үр дүн	4,964.8	5,885.5	920.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,213.9	5,436.3	222.4
Дүн	40,444.8	47,393.3	6,948.5

Эх сурвалж: (Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө: Өмнөх оноос 650.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ, Энхтүсдэм ӨЭМТ, Сум дундын ойн анги газар эзэмших эрх бүртгэсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн: 6,076.0 сая төгрөгөөр нэмэгдэж 19,547.1 сая төгрөгийг тайлагнасан нь тайлант үеийн үр дүн 5,885.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү: 222.4 сая төгрөгөөр буурсан нь данснаас хасагдсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл байна.

Ерөнхий чиглэлийн судалгааны үр дүн:

2025-2026 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд ирүүлсэн 8 төрлийн судалгааг ТЕЗ-ийн нэгтгэлд хамрагдсан байгууллагуудаар нэгтгэсэн. Үүнд:

- Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын судалгаа:** Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх заалт, хөдөлмөрийн дотоод журмын дагуу 18 байгууллага нийт 1,182.6 сая төгрөгийг хоолны зардалд зарцуулсан бөгөөд нэг өдрийн хоолны мөнгө 5.0-21.0 мянган төгрөгийн хооронд олгосон байна. Иймд аймгийн Засаг даргад ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хоолны хөнгөлөлтийн тариф ижил тогтоох зөвлөмж өгсөн.
- Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардлын судалгаа:** Гадаад томилолтыг 3 байгууллага олгосон бөгөөд 11 үйл ажиллагааны томилолтын зардалд 57.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: АЗДТГ-аас гадаад харилцаа хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 7 үйл ажиллагаанд 26 албан хаагчдыг хамруулж 50.5 сая төгрөг, УС-ДУ ОНӨААТҮГ-ын төлөвлөгөөний дагуу 2 инженерийг Польш улсын усан хангамжийн талаар сургалтад хамруулж 4.0 сая төгрөг, Шивээговь сумын Засаг даргын тамгын газраас 2 үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын судалгаа:** Шивээговь сумын Засаг даргын 2020 оны Б/31 дугаар тушаалаар Засаг даргын Тамгын газрын дарга Д.Отгонжаргалыг ажлаас чөлөөлсөн шийдвэрийг шүүхээс хүчингүй болгож шийдвэрлэсэн тул 31.9 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Төрд учирсан хохирлыг барагдуулах албан шаардлагыг өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

4. **Программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой судалгаа:** Программ хангамжийн бүртгэлийн хувьд 15 байгууллагын 37 программ хангамжийг 80.5 сая төгрөгөөр гэрээ байгуулж худалдан авч нэмэлт хөгжүүлэлтэд 2.9 сая, засвар үйлчилгээний төлбөрт 8.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Санхүүгийн тайланд 81.8 сая төгрөгийн бүртгэлтэй 37 программ хангамж бүртгэлтэй байгаагаас 30 программ хангамжийг ашиглаж байна. Тайлант хугацаанд 6.5 сая төгрөгийг программ ашиглах эрхийн лицензийн төлбөрт зарцуулсан байна.
5. **Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардлын судалгаа:** Сургалт, зөвлөгөөнд 5 байгууллага нийт 49 арга хэмжээнд 218.9 сая төгрөгөөр зохион байгуулахаар төлөвлөснөөс 37 арга хэмжээнд 72.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон арга хэмжээнд зарцуулаагүй байна.
6. **Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс авах судалгаа:** Орон нутгийн өмчит 5 байгууллагаас 4 байгууллага судалгаанд хамрагдсанаас дулаан үйлдвэрлэн түгээх 3, хог хаягдал цэвэрлэн, тээвэрлэх булшлах 1 байгууллага байна. Тус байгууллагуудын улсын бүртгэлийн хөрөнгийн дүн нийт 5,260.8 сая төгрөг, санхүүгийн тайлангийн орон нутгийн эзэмшигчийн өмчийн дүн 5,261.9 сая төгрөг байна. ОНӨААТҮГ-ын ажилчдын тоо 222 бөгөөд цалингийн зардал 3,620.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд болох нийт орлого 8,569.1 сая, нийт зардал 9,569.1 сая, нийт хөрөнгө 28,268.7 сая, өр төлбөр 21,924.9 сая төгрөг байна. Тайлант оны эдийн засгийн зорилтот түвшний алдагдал 1,000.0 сая төгрөг болсон нь үйлчилгээний үнэ тарифыг нэмэгдүүлэхээр тооцоолсон боловч үнэ нэмэх шийдвэр гараагүйгээс алдагдалтай ажилласан байна.
7. **Байгууллагуудын орон тооны цомхотголын судалгаа:** 2025 онд ТЕЗ-ийн харьяа байгууллагууд орон тооны цомхотгол хийгээгүй байна. 2025 оны батлагдсан нийт орон тоо 413 бөгөөд 12,970.0 сая төгрөг, тогтоолоор 459 болж 11,692.1 сая төгрөг 46 орон тоо нэмэгдсэн нь УС-ДУ ОНӨААТҮГ-д Төмөр замын 46 орон тоо нэмэгдсэнтэй холбоотой байна. Гүйцэтгэлээр нийт 416 орон тоотойгоор 11,523.0 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулсан байна.
8. **Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээллийн судалгаа:** Мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн 3 байгууллага нийт 28.5 сая төгрөгийн 7 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулснаас гүйцэтгэлээр 27.5 сая төгрөгийг зарцуулж, 6 гэрээ нь 100%-тай дүгнэсэн бөгөөд 1 гэрээний 50%-тай хэрэгжсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн Засаг даргын 2025 оны төсвийг Сангийн яамнаас хянаж батлахдаа татварын орлогыг 15,008.1 сая, татварын бус орлогыг 1,476.0 сая, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 11,725.4 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 8,374.3 сая, нийт 36,583.8 сая төгрөгөөр, суурь зарлагыг 28,209.5 сая, ОНХС-гийн орлогын шилжүүлэг 8,374.3, нийт 36,583.8 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн Засаг даргаас төсвийн суурь орлогыг 431.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 16,915.1 сая, бусад эх үүсвэрээс буюу аймаг, сумдын 2024 оны давсан орлого, хэмнэгдсэн зардал 3,313.4 сая, ОНХС, ОНХО-ын он дамжин хийгдэх ажлуудын эхний үлдэгдэл 1,157.0 сая, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 11,725.4 сая, ОНХС-аас олгох шилжүүлэг 8,374.3 сая, нийт 41,485.6 сая төгрөгийн эх үүсвэр төлөвлөж Төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар ирүүлжээ.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 05 дугаар тогтоолоор төсвийн төслийн саналыг 361.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 41,847.0 сая төгрөг болгон тодотгож баталжээ. Анх баталсан төсвийг аймгийн ИТХ-ын 2025.07.28-ны өдрийн 02 дугаар тогтоолоор төсвийг 2,782.2 сая төгрөгөөр бууруулан 39,064.8 мянган төгрөгөөр тодотгож баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 22 хөтөлбөрт зориулан 39,064.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 24,386.3 сая төгрөгийг урсгал зардалд, 13,470.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 1,208.4 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 5,829.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 5,119.7 сая, 16,730.0 сая төгрөгийг татварын орлогоос, 397.3 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 1,820.0 сая төгрөгийг торгуулийн орлогоос, 190.3 сая төгрөгийг түрээсийн орлогоос, 8,977.8 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Төсвийн гүйцэтгэлээр 5,766.6 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 336.9 сая, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 5,119.7 сая, татварын орлогоос 19,340.9 сая, торгууль болон түрээсийн орлогоос 1,840.5 сая, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг ерөнхий орлогын дансанд төвлөрүүлснээс 103.7 сая, урьд оны үлдэгдлээс нийт 32,508.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 21,684.0 сая, хөрөнгийн зардалд 9,100.2 сая, эргэн төлөгдөх зээлийн зардалд 531.7 сая нийт 31,315.9 сая төгрөгийг зарцуулж 1,192.4 сая төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна.

Орлогын гүйцэтгэлийн талаар:

Аймгийн ИТХ-ын 2025.07.28 №05, Сүмбэр сумын ИТХ-ын 2025.09.24 №03, Шивээговь сумын ИТХ-ын 2024.09.24-ний 03, Баянтал сумын ИТХ-ын 2025.08.12-ны 04 дүгээр тогтоолоор тайлант онд нийт орлого ба тусламжийн орлого 30,087.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 32,508.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №15

(сая төгрөгөөр)

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	11,780.8	14,023.0	(2,242.2)	119%
2	Үйл ажиллагааны орлого	100.0	151.1	(51.1)	151%
3	Хөрөнгө борлуулсны орлого	290.0	247.5	42.5	85%
4	Хөрөнгийн орлого	590.0	427.0	163.0	72%
5	Шууд бус орлого	430.0	557.6	(127.6)	130%
6	Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(500.0)	(500.0)	-	100%
7	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	746.0	778.4	(32.4)	104%
8	Бууны албан татвар	6.8	6.1	0.7	90%
9	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	166.0	165.3	0.7	100%
10	Улсын тэмдэгтийн хураамж	80.0	141.4	(61.4)	177%
11	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	37.0	44.1	(7.1)	119%
12	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	250.0	272.7	(22.7)	109%
13	Газрын төлбөр	526.0	977.9	(451.9)	186%
14	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	630.0	704.4	(74.4)	112%
15	Дуудлага худалдаа	873.4	946.2	(72.8)	108%
16	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	54.1	83.3	(29.2)	154%
17	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	650.0	206.4	443.6	32%
18	Малын тоо толгойд ногдуулах албан татвар	20.0	108.6	(88.6)	543%
	Татварын орлогын дүн	16,730.1	19,341.0	(2,610.9)	115%

(Эх сурвалж: Татварын газар, аймгийн СТСХ-ийн мэдээ, аудитын ажлын баримт)

Тайлант оны татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 115 хувиар давж биелсэн боловч орлогын нэр, төрлөөрөө 12 нэр, төрлийн орлого нийт 3,261.4 сая төгрөгөөр давж, 5 орлогын төлөвлөгөө нийт 650.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Давсан татварын орлого нь 3,261.4 сая төгрөгийн дараах орлогууд байна. Үүнд:

- ✚ Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого 2,242.2 сая
- ✚ Үйл ажиллагааны орлого 51.1 сая
- ✚ Шууд бус орлого 127.6 сая
- ✚ Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 32.4 сая
- ✚ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 74.4 сая
- ✚ Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 61.4 сая
- ✚ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 22.7 сая
- ✚ Газрын төлбөр 451.9 сая
- ✚ Дуудлага худалдааны орлого 72.8 сая
- ✚ Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 7.1
- ✚ Ан амьтны нөөц ашигласны төлбөр 29.2 сая
- ✚ Малын тоо толгойд ногдуулах албан татварын орлого 88.6 сая

Тасарсан татварын орлого нь 650.5 сая төгрөгийн дараах орлогууд байна. Үүнд:

- ✚ Хөрөнгө борлуулсны орлого 42.5 сая
- ✚ Хөрөнгийн орлого 163.0 сая
- ✚ Бууны албан татварын орлого 0.7 сая
- ✚ Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 0.7 сая
- ✚ Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 443.6 сая

Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №16

(сая төгрөгөөр)

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хүү, торгуулийн орлого	1,800.0	1,667.6	132.4	92.6%
Түрээсийн орлого	190.3	172.9	17.1	91%
Төсөвт байгууллагын өөрийн орлого	61.0	85.8	-24.8	141%
Дүн	2,051.3	1,926.3	124.7	94%

Тайлант онд 2,051.3 сая төгрөгийн татварын бус орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,926.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 94 хувиар биелүүлсэн байна.

Улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №17

(сая төгрөгөөр)

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	5,829.7	5,766.6	63.1	99%
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	5,119.7	5,119.7	0.0	100%
Нийт дүн	10,949.4	10,886.3	63.1	99.4%

Тайлант онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого төлөвлөгөөнөөс 63.1 сая төгрөгөөр буюу 1 хувиар дутуу санхүүжсэн байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 100 хувь санхүүжсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Орлогын бүртгэл тайлагналтай холбоотой 86.7 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 398.8 сая төгрөгийн 3 зөвлөмж, 10.0 сая төгрөгийн 1 албан шаардлага өгсөн байна. Үүнд:

1. Шивээговь сумын ТТЗ-ийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд бусад орлогыг 0.1 сая төгрөгийг илүү тайлагнасан байсныг залруулсан.
2. Шивээговь сумын ТТЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн бусад орлогыг 11.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан байсныг залруулсан.

3. Баянтал сумын ХХС-ийн тайланд орлогыг 1.8 сая төгрөгийг андуурч буруу бүртгэсэн байсныг залруулсан.
4. Талын илч ОНӨААТҮГ-ын урьдчилж орсон орлогыг 72.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан байсныг залруулсан.
5. Сүмбэр сумын ТТЗ-ийн тайланд татварын орлогын төлөвлөгөө 393.4 сая төгрөгөөр тасарсан, хуулиар тогтоосон орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй зөрчил илэрсэн тул зөвлөмж өгсөн.
6. Шивээговь сумын ТТЗ-ийн тайланд Шивээговь сумын соёлын төвийн тогтмол зардлын санхүүжилтийг батлагдсан төсвөөс 2.1 сая төгрөгөөр хэтрүүлэн олгосон тул зөвлөмж өгсөн.
7. Илчлэг-шивээ ОНӨААТҮГ-ын Ус, дулааны авлагын эцсийн үлдэгдлийг анхан шатны баримтуудтай /ААНБ, айл өрхийн 1-12 сарын ус, дулааны бичилт, нэхэмжлэх, борлуулалтын дэвтэр/ тулгахад 3.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн тул зөвлөмж өгсөн.
8. Шивээговь сумын ХХС-гийн тооцооллын илүү төлөвлөлт, хугацаа хэтэрсэн авлагаас шалтгаалан ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөөг 20.4% буюу 10.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгсөн байна.

Зарлагын гүйцэтгэлийн талаар:

2025 онд 39,064.8 сая төгрөгийн зардал төлөвлөснөөс 31,315.9 сая төгрөгийг зарцуулж 7,748.9 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт № 18

(сая төгрөгөөр)

№	Хөтөл- бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн гүйцэтгэлийн %
1	70105	ОН-ийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2,224.3	1,996.3	228.0	89.7%
2	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	12,603.3	11,247.0	1,356.4	89.2%
3	71502	Хот байгуулалт, тохижилт	274.6	259.0	15.6	94.3%
4	70426	Төрийн өмчийг хэрэгжүүлэх	262.5	207.6	54.9	79.1%
5	70418	Худалдан авах ажиллагаа	268.5	225.1	43.4	83.8%
6	70417	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	357.3	351.6	5.6	98.4%
7	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	714.7	650.7	64.0	91.0%
8	71403	Ойжуулах	457.1	432.6	24.5	94.6%
9	71902	Нийгмийн халамж	40.8	14.6	26.1	35.9%
10	71701	Биеийн тамир, спорт	667.8	595.3	72.5	89.1%
11	71602	Эрүүл мэнд	1,268.4	1,227.6	40.8	96.8%
12	71702	Соёл урлаг	301.2	232.0	69.2	77.0%
13	71806	Насан туршийн боловсрол	5.0	5.0	-	100.0%
14	71804	Мэргэжлийн боловсрол	765.0	714.8	50.2	93.4%
15	71802	Ерөнхий боловсрол	1,690.1	1,603.6	86.4	94.9%
16	71801	Сургуулийн өмнөх боловсрол	671.4	648.6	22.7	96.6%
17	70801	Мал аж ахуй хөгжүүлэх	147.7	121.7	26.0	82.4%
18	72208	Ахмад настны хөгжил, хамгаалал	135.0	135.0	-	100.0%
19	71101	Автозам	1,098.5	756.9	341.6	68.9%
20	72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	1,208.4	531.8	676.6	44.0%
21	72203	Хүүхдийн хөгжил, хамгаалал	50.0	45.3	4.7	90.6%
22	70503	Орон нутгийн хөрөнгө оруулалт	13,853.3	9,313.8	4,539.5	67.2%
Нийт			39,064.8	31,316.0	7,748.9	80.16%

Эх сурвалж: (Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Үүнээс: Материаллаг хэмжээний хэмнэлт үүссэн байгууллагууд:

- Аймгийн ЗДТГ: **619.9 сая**
- Орон нутгийн өмчийн газар **54.8 сая**
- Худалдан авах ажиллагааны газар **43.4 сая**
- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт: **2,303.3 сая**
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сан: **886.7 сая**

- Халамжийн сан: **26.1 сая**
- Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан: **553.1 сая**
- Шивээговь сумын ЗДТГ: **215.6 сая**
- Баянтал сумын орон нутгийн хөгжлийн сан: **128.4 сая**
- Баянтал сумын ЗДТГ: **169.3 сая**
- Шивээговь сумын Хоршоо хөгжүүлэх сан: **47.3 сая**
- Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сан: **667.8 сая**
- Сүмбэр сумын ЗДТГ: **189.4 сая**
- Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сан: **598.7 сая**

Аудитын илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэл, зардлын бүртгэл тайлагналтай холбоотой 274.6 сая төгрөгийн 7 алдааг аудитын явцад залруулж, 421.6 сая төгрөгийн 21 албан шаардлага, 27.2 сая төгрөгийн 23 зөвлөмж, 14.0 сая төгрөгийн 12 төлбөрийн акт, санхүүгийн үйл ажиллагааг зүй зохистой удирдан зохион байгуулаагүй, аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, давтан зөрчил гарсан 2 албан тушаалтанд хариуцлага тооцох 2 албан шаардлага тус тус тогтоосон байна. Үүнд:

Аудитаар залруулсан алдаа: Шивээговь сумын ТТЗ буюу засаг дарга 265.7 сая, ЗДТГ нь 4.3 сая, Илчлэг шивээ ОНӨААТҮГ 4.2 сая төгрөгийн алдаатай бүртгэлийг аудитын явцад залруулсан.

Төлбөрийн акт:

УСДУ ОНӨААТҮГ албан хаагчдад 2.1 сая төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон, Баянтал сумын ТТЗ буюу Засаг дарга 2.9 сая захиалагчийн хяналтын зардлыг зориулалт бусаар зарцуулсан, Шивээговь сумын ОНХС-гаас 0.2 сая төгрөгийг төсөв хэтрүүлэн зарцуулсан, аймгийн ИТХ 0.5 сая, Сүмбэр сумын ИТХ 0.5 сая төгрөгийн хоолны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулж олгосон, аймгийн ЗДТГ 11 албан хаагчдад 0.5 сая төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлтийг эдлүүлээгүй, Сүмбэр сумын ЗДТГ 1 албан хаагчийн цалин хөлсийг илүү тогтоож 1.6 сая төгрөгийн илүү цалин олгосон, Шивээговь сумын ЗДТГ 5 албан хаагчид хууль тогтоомжид олгохоор тусгайлан заагаагүй тэтгэмжийг олгохдоо 0.3 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй, СХДАА 1.1 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүй олгосон, СДОА 0.1 сая төгрөгийн зардлыг дээд шатны төсөв захирагчийн шийдвэргүйгээр зарцуулсан зөрчилд тус тус төлбөрийн акт тогтоосон байна.

Албан шаардлага:

Аймгийн ЗДТГ-30.1 сая Сүмбэр сумын ЗДТГ-13.0 сая, Баянтал сумын ЗДТГ-7.1 сая, СДАА-4.4 сая, аймгийн ИТХ-1.9 сая, Баянтал сумын ИТХ-3.4 сая, ахмадын хороо-1.2 сая, Баянтал сумын ОНХС-9.5 сая, аймгийн ОНХС-60.3 сая, Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сан-207.0 сая, Сүмбэр сумын ОНХС-43.6 сая, Шивээговь сумын ОНХС-2.0 сая, Илчлэг шивээ ОНӨААТҮГ-6.0 сая, УСДУ ОНӨААТҮГ-31.5 сая төгрөгийн зардлыг Төсвийн тухай хуулийн дагуу үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй тул зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Зөвлөмж:

Аймгийн ЗДТГ-т 8.2 сая төгрөгийн 3, Орон нутгийн өмчийн газарт 1, Сүмбэр сумын ИТХ-д 1, Худалдан авах ажиллагааны газарт 1, Шивээговь сумын ЗДТГ-т 1.3 сая төгрөгийн 1, аймгийн ИТХ-д 8.9 сая төгрөгийн 1, Чойр хотын захирагчийн ажлын албанд 1, Илчлэг шивээ ОНӨААТҮГ-т 1.5 сая төгрөгийн 1, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-т 0.1 сая төгрөгийн 1, УСДУ ОНӨААТҮГ-т 7.0 сая төгрөгийн 1 зөвлөмжийг төсвийн зарцуулалтын үр дүн, тайлагнал, дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр тус тус өгсөн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 35.7 сая, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 82.6 сая, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 32.6 сая, эхний үлдэгдэл 84.5 сая нийт 235.4 сая төгрөгийг хүлээн авсан байна.

Үүнээс: Цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 41.8 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 5.3 сая, хангамж, гэрэл цахилгааны зардалд 0.7 сая, хангамж, бараа материалын зардалд 9.7 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 1.2 сая, томилолтын зардалд 0.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 27.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 115.9 сая нийт сая төгрөгийг зарцуулж 32.1 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй боловч тус дансны харилцахын үлдэгдлээр тайлагнах мөнгөн хөрөнгийг ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн ИТХ-ын 2025.07.28 оны 02 дугаар тогтоолоор ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийн дагуу 22 хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг 88.3 хувьтай тайлагнасан байна.

Хүснэгт 19. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт (мянган төгрөгөөр)

№	Хөтөлбөрийн код	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Төсвийн гүйцэтгэлийн %	Хөтөлбөрийн гүйцэтгэл
1	70105	2,224,342.0	1,996,312.5	89.75%	116.8%
2	70106	12,603,346.0	11,246,989.9	89.24%	103.5%
3	71502	274,590.0	259,024.5	94.33%	162.6%
4	70426	262,460.0	207,593.2	79.10%	106.7%
5	70418	268,530.0	225,128.5	83.84%	93.2%
6	70417	357,260.0	351,612.3	98.42%	87.7%
7	71411	541,370.0	507,151.3	70.97%	98.9%
		173,270.0	143,515.7		97.6%
8	71403	457,110.0	432,574.0	94.63%	21.0%
9	71902	40,750.0	14,625.0	35.89%	-40.0%
10	71701	667,830.0	595,293.3	89.14%	238.0%
11	71602	1,268,420.0	1,227,644.6	96.79%	100.0%
12	71702	301,180.0	231,975.4	77.02%	100.0%
13	71806	5,000.0	5,000.0	100.00%	100.0%
14	71804	765,000.0	714,806.5	93.44%	100.0%
15	71802	1,690,080.0	1,603,640.4	94.89%	100.0%
16	71801	671,370.0	648,649.4	96.62%	100.0%
17	70801	35,768.3	35,768.1	100.00%	125.2%
		111,931.7	85,932.0	76.77%	105.3%
18	72208	135,000.0	135,000.0	100.00%	139.9%
19	71101	1,098,500.0	756,895.9	68.90%	66.0%
20	72101	300,000.0	300,000.0	100.00%	100.0%
		908,404.7	231,755.5	25.51%	100.0%
21	72203	50,000.0	45,293.4	90.59%	160.0%
22	70503	13,853,316.1	9,313,811.3	67.23%	88.9%
Нийт		39,064,828.8	31,315,992.7	80.16%	88.3%

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Хүснэгтээс харахад: Төлөвлөсөн хөтөлбөрүүдийн төсвийн гүйцэтгэл 80.1 хувь, хөтөлбөрүүдийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын үзүүлэлт 88.3 хувьтай хэрэгжсэн гэж аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс үнэлсэн байна.

4.5.5 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа

Говьсүмбэр аймагт цэвэр ус, дулаанаар хангах, бохир усыг татан зайлуулах 3, тохижилт үйлчилгээний 1 нийт 4 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар ажиллаж байна.

ОНӨААТҮГ-дын үйл ажиллагаа зорилтот түвшин, гүйцэтгэл

Хүснэгт №20

(сая төгрөгөөр)

Байгууллагын нэр	Зорилтот түвшин			Гүйцэтгэл		
	Орлого	Зардал	Цэвэр Ашиг/ алдагдал	Орлого	Зардал	Цэвэр Ашиг/ алдагдал
Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ						

Илчлэг шивээ ОНӨААТҮГ	1,544.9	1,655.1	(110.2)	1,254.1	1,232.8	21.3
УСДУ ОНӨААТҮГ	3,701.4	4,299.8	(598.4)	4,437.5	4,970.1	(532.6)
Талын илч ОНӨААТҮГ	939.0	872.6	66.4	661.3	748.1	(86.8)
Нийт	6,185.3	6,827.5	(642.2)	6,352.9	6,951.0	(598.1)

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Хүснэгтээс харахад: Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд алдагдлын хэмжээг 642.2 сая төгрөгөөр тооцсон бөгөөд гүйцэтгэлээр Илчлэг шивээ ОНӨААТҮГ 21.3 сая төгрөгийн ашигтай, УСДУ, Талын Илч ОНӨААТҮГ нийт 619.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Ашигт ажиллагаанд нөлөөлж байгаа хүчин зүйл нь нүүрс, цахилгаан болон шатахууны үнэ нэмэгдсэн байхад дулааны үнэ тариф нэмэгдээгүй байдал нь нөлөөлж байна.

Мөн УСДУ ОНӨААТҮГ нь УБТЗХНН-н Чойр хэсгийн 1, 2, 3 дугаар уурын зуухыг аймгийн ИТХ-ын 2025.06.20-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор хүлээн авсан. Хөрөнгө, зардал нэмэгдсэн боловч үнэ тариф нэмэгдээгүйгээс ашигт ажиллагаа алдагдаж 1,185.5 сая төгрөгийн өр төлбөр бүртгэсэн байна. Нөгөө талаар 850.0 сая төгрөгийн авлага бүртгэсэн боловч барагдуулах ажлыг хийж чадахгүй байгаа нь тус байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Иймд тус байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, үнэ тарифыг шинэчлэх, авлага, өр төлбөрийг барагдуулахад анхаарах шаардлагатай байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/430 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 32,037.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 480.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан гүйцэтгэж, 5 байгууллагаас 197.4 сая төгрөгийн 8 зөрчил илэрч 20.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 1.3 сая төгрөгийн 1 зөвлөмж, 2.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 173.7 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах саналыг тус тус хүргүүлсэн байна. Үүнд:

- **Баянтал сумын ОНХС:** Шилэн дансны цахим хуудсанд 173.7 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроосон, өмнөх аудитаар зөрчил арилгуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн.
- **Баянтал сумын ЗДТГ, ОНХС:** Өмнөх аудитаар насжилт өндөр байгаа авлагыг барагдуулах зөвлөмжийг өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй тул 13.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, тэмцээн уралдаан, шагнал урамшуулал зарцуулсан 1.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- **Илчлэг шивээ, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ:** Суудлын автомашинд шатахуун хэрэглэсэн боловч зарцуулалтад тавих хяналтгүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчилд 7.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.
- **Шивээговь сумын ЗДТГ:** Хог тээврийн автомашинд төлөвлөсөн зардлаас хэтрүүлж зарцуулсан 1.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, аймаг сумын хооронд тогтоосон маршрут, явсан км-ээс хэтрүүлж зарцуулсан шатахууны 0.8 сая төгрөгийн зөрчилд тус тус төлбөрийн акт тогтоосон.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа 15 байгууллагад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,448.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 1,282.2 сая төгрөгийн 12 зөрчилд албан шаардлага, 35.1 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, 131.0 сая төгрөгийн 2 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага тус тус өгсөн байна.

Өмнөх онд 17 байгууллагад Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,250.5 сая төгрөгийн зөрчил илэрч, 9 байгууллагад 246.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж, 7 байгууллагад 960.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, давтан гаргасан 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал өгсөн бөгөөд тайланд онд зөрчлийн дүн 197.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд 28 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, хугацаа хоцроосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Ил тод байдлыг хангасан байх”, 6 дугаар зүйлийн 6.5.3-т “төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах”, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:” 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6.1.6 “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр.”, 6.2.5-т “улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа”, 6.3.8-т “тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт” гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах, ил тод байдлыг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлангийн аудитыг нийцлийн аудиттай хослуулан худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж буй эсэхэд горим сорил хэрэгжүүлэхэд худалдан авах ажиллагаатай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын хийгээгүй.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 22. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар			Биелэлт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	32.2	1	32.2	100%
Албан шаардлага					
Зөвлөмж	3	1,209.4	2	1,149.1	98%
Нийт дүн	4	1,241.6	1	1,181.3	

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт бүрэн хэрэгжсэн бол авлага бууруулах 101.4 зөвлөмжөөс 41.2 сая төгрөг нь хэрэгжиж, Энхтүсдэм ӨЭМТ-ийг аудит хамруулах зөвлөмж хэрэгжээгүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил:

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 15 төсвийн байгууллага, ОНӨҮГ болон ААТҮГ-6, тусгай сан 8, төсвийн төвлөрүүлэн захирагч 3 нийт 32 тайлан нэгтгэгдсэнээс 16 байгууллагад дүгнэлт гаргаж, 15 байгууллага түүвэрт хамрагдаж 1 байгууллага татгалзсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”-13, “хязгаарлалттай”-3 /Шивээговь, Сүмбэр, Баянтал сумын төвлөрүүлэн захирагч “Татгалзсан”-1 /Энхтүсдэм ӨЭМТ/ санал дүгнэлт тус тус өгчээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 7,027.2 сая төгрөгийн 148 алдаа зөрчил илрүүлэн, 42.0 хувь буюу 2,947.7 сая төгрөгийн 49 алдааг аудитын явцад залруулж, 47 хувь буюу 3,272.6 сая төгрөгийн 46 зөрчлийг арилгах албан шаардлага, 0.4 хувь буюу 17.7 сая төгрөгийн 15 төлбөрийн акт тогтоож, 7 хувь буюу 484.4 сая төгрөгийн 32 зөрчлийг арилгах зөвлөмж, 4 хувь буюу 304.7 сая төгрөгийн зөрчилд 6 хариуцлага тооцуулах албан шаардлага өгсөн байна.

Үүнээс нийцлийн аудиттай холбоотой зөрчил нийт зөрчлийн 2,311.4 сая төгрөг болж өмнөх оноос 810.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант хугацааны нийт зөрчилд нийцлийн аудитын зөрчил 57 хувийг эзэлж байна.

Хүснэгт 23. Харьяа байгууллагад илэрсэн алдаа зөрчлийг өмнөх онтой харьцуулбал

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Тайлант оны нийт илрүүлэлт		Үүнээс: Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал		СТА-ын алдаа, зөрчил	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга	46	1,659.4	49	2,947.7			49.0	2,947.7
Залруулаагүй алдаа	83	3,307.8	99	4,079.5	34	2,311.4	65.0	1,768.1
Төлбөрийн акт	14	41.4	15	17.7			15.0	17.7
Албан шаардлага	29	1,758.1	46	3,272.6	20.0	1,963.2	26.0	1,309.4
Зөвлөмж	38	1,458.7	32	484.4	8.0	43.5	24.0	440.9
Хариуцлага тооцуулах Санал	2	49.6	6	304.7	6.0	304.7	-	-
Нийт	129	4,967.2	148	7,027.2	34	2,311.4	114.0	4,715.8

(Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн аудитын систем)

Хүснэгтээс харахад: Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад илэрч буй алдаа, зөрчил өмнөх оноос 2,060.0 сая төгрөгөөр буюу 1.4 дахин нэмэгдсэн байна.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ-НЭГТГЭСЭН ТАЙЛАНТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 2,187.7 сая төгрөгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, нийцлийн аудиттай холбоотой алдаа, зөрчил илэрсэн.

Үүнээс 894.4 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, нийцлийн аудиттай холбоотой 3 зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд 1,293.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 1,293.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчлийг материаллаг гэж үнэлсэн бөгөөд тогтоосон материаллаг байдлын түвшин 480.5 сая төгрөгөөс хэтэрсэн тул **ХЯЗГААРЛАЛТТАЙ** санал дүгнэлтийг хүргүүлээ.

Мөн Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлан хязгаарлалттай дүгнэлт авсан. Санхүүгийн нэгтгэсэн тайланд Энхтүсдэм ӨЭМТ татгалзсан дүгнэлттэйгээр нэгтгэгдсэн зэрэг нь нөлөөлсөн. Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дээрх залруулаагүй зөрчлийг материаллаг хэмжээний боловч өргөн тархаагүй гэж үзсэн тул хязгаарлалттай дүгнэлт өгсөн болно.

Аудитаар нийт **894.4** сая төгрөгийн алдаа¹ залруулсан байна.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд УСДУ ОНӨААТҮГ-ын аудит хийж баталгаажуулсан тайлангийн нийт зардлыг 298.2 сая төгрөгөөр бууруулан бүртгэж, тайланг үнэн зөв нэгтгээгүй.
- Тайлант хугацаанд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгын ажлыг бүрэн гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авсан боловч гэрээний дагуу Өрнөх бьюлдинг ХХК-д олгох 212.9 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгээгүй. Тайлант оны ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч аккурэль сууриар бүртгээгүй.
- Тайлант хугацаанд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилгын ажлыг бүрэн гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авсан боловч Хан аттрибут ХХК-д илүү олгосон 212.9 сая төгрөгийн санхүүжилтийг авлага үүсгэж бүртгээгүй. Тайлант оны ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч аккурэль сууриар бүртгээгүй
- ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд татан буулгах шийдвэр гарсан ЦСҮТ ОНӨҮГ-ын 2025 оны жилийн эцсийн хаалтын тайлан хийгээгүй, тайланд бүртгэлтэй 170.4 сая төгрөгийн авлагыг Засаг дарга дансанд давхар бүртгэсэн.

Аудитаар нийт 1,293.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 1,171.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, 121.9 сая төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

5.2.1 Татварын бус орлогын төлөвлөгөөг 125.0 сая төгрөгөөр биелүүлээгүй, хуулиар тогтоосон орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т *“өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”*, 41 дүгээр зүйлийн 41.2.1-т *“хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”*, УСНББОУС "Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал" нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж баталгаажуулаагүй "Энхтүсдэм" өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг нэгтгэсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйл, Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2024.07.08-ны өдрийн А/320 дугаар тушаалаар баталсан "Өрхий эрүүл мэндийн төвийн дүрэм"-ийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6 дугаар зүйлийн 6.6-д “Төв нь өөрийн үйл ажиллагаанд аудитын дүгнэлт, зөвлөмж гаргуулсан байна.”, УСНББОУС Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал, иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Энхтүсдэм ӨЭМТ-ийн аудит хийж баталгаажуулсан тайланг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэн тайлагнах албан шаардлага өгөх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт, дотоод хяналттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг Засаг дарга дансанд төлөвлөж, төсвийн шууд захирагчдын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн боловч арга хэмжээний хэрэгжилт, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д “Төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг”, 5 дугаар зүйлийн 5.1.5-т “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 41 дүгээр зүйлийн 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.”, УСНББОУС Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж:

Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэл, төсвийн зарцуулалтын байдалд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, гүйцэтгэл үр дүнг тооцож, нэгтгэн тайлагнах

2. Ажиллагсад олгох хоол, унааны хөнгөлөлт

2.1 Илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагууд төрийн албан хаагчдад олгох хоол, унааны хөнгөлөлтийн зардлыг аймаг, сум, төсвийн шууд захирагч бүр харилцан адилгүй тогтоосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж:

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын хоол унааны хөнгөлөлтийн зардлын хэмжээг аймгийн хэмжээнд нэгдсэн журмаар ижил тариф тогтоох

3. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Санхүүгийн нэгтгэсэн тайланд Сүмбэр сумын Засаг даргын аудит хийж баталгаажуулсан санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг 121.9 сая төгрөгөөр илүү бүртгэж, тайланг үнэн зөв нэгтгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “Үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5 дугаар зүйлийн 5.1.5-т “Хариуцлагатай байх”, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 “Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн ерөнхий, ахлах нягтлан бодогч нь энэ журмын 4.1-д зааснаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ.”, 4.2.1-т “Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын гаргалт, тооллого тооцоо, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг өөрийн болон харьяа байгууллагадаа байнга шалган зааварчилж байх”, 4.2.2-т “Харьяа байгууллагын улирал жилийн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн холбогдох журнал болон ерөнхий данс, тооллого, тооцооны материалтай тулган шалгаж, хүлээн авч нэгтгэн үнэлэлт дүгнэлт өгч байх.” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж:

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитад хамрагдсан тайланг үнэн зөв нэгтгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх

4. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын даргын захирамжаар ЦСҮТ ОНӨҮГ-г татан буулгах шийдвэр гарсан боловч хаалтын тайланг бэлтгээгүй, улсын бүртгэлээс хасуулаагүй.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 “аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ-ын санхүүгийн тайлан дахь авлагын асуудлыг хууль журмын дагуу шийдвэрлүүлж, хаалтын тайланг бэлтгэн, улсын бүртгэлээс хасуулах

Дээрх шийдвэрүүдийг хугацаанд нь хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говьсүмбэр аймгийн ТЕЗ	4	894.4	2	425.8	2	468.6	4	889.4				
Дүн	4	894.4	2	425.8	2	468.6	4	889.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говьсүмбэр аймгийн Засаг дарга	4	1,293.3			2	1,171.4	2	121.9				
Дүн	4	1,293.3			2	1,171.4	2	121.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Говьсүмбэр аймгийн Засаг дарга	1	0					1	0
Дүн	1	0					1	0

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Говьсүмбэр аймгийн Засаг дарга	2	0					2	0
Дүн	2	0					2	0
Нийт дүн	3	0					3	0

ТЕЗ-ИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2025 ОНЫ АУДИТЫН ДҮГНЭЛТ, АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

№	Байгууллага нэгжийн нэр	Байгууллагын регистрийн дугаар	2025 оны санхүүгийн тайлангийн аудит				Дүгнэлт		
			АНАГ	АХЭ	Түүвэрт	Дүгнэлт гараагүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалт тай	Татгалзсан
1	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9018662	1				1		
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	9018948	1				1		
3	Орон нутгийн өмчийн газар	4614909	1		1				
4	Худалдан авах ажиллагааны газар	4617894		1			1		
5	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	9018948	1		1				
6	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	4614194	1		1				
7	Халамжийн сан	9019308	1		1				
8	Байгаль орчин аялал жуулчлалын газар	9019197		1			1		
9	Чойр хотын захирагчийн ажлын алба	4618629	1				1		
10	Сум дундын ойн анги	8131953	1		1				
11	Аймгийн Ахмадын хороо	8239584	1		1				
12	Сүмбэр сумын Засаг дарга	9018611	1					1	
13	Шивээговь сумын Засаг дарга	9018441	1					1	
14	Баянтал сумын Засаг дарга	9018522	1					1	
15	Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар	9018611	1				1		
16	Шивээговь сумын Засаг даргын тамгын газар	9018441	1				1		
17	Баянтал сумын Засаг даргын тамгын газар	9018522	1				1		
18	Сүмбэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9018964	1		1				
19	Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9018387	1		1				
20	Баянтал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	9018867	1		1				
21	Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан	9018611	1		1				
22	Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан	9018441	1		1				
23	Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сан	9018522	1		1				
24	Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	9018611	1		1				
25	Шивээговь сумын Хоршоо хөгжүүлэх сан	9018441	1		1				
26	Баянтал сумын Хоршоо хөгжүүлэх сан	9018522	1		1				
27	"Цөм сүргийн үржлийн төв" ОНӨҮГ	4611918	1				1		
28	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ	2005093	1				1		
29	Талын илч ОНӨААҮГ	2005166	1				1		
30	Илчлэг-Шивээ ОНӨААТҮГ	2005123	1				1		
31	Ус-Ду ОНӨААТҮГ	2004933	1				1		
32	Сүмбэр сумын Энхтүсдэм ЗГБХН өрхийн ЭМТ	2005344	1						1
Бүгд			30	2	15	0	13	3	1

ТЕЗ-ИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН АСУУДЛЫН БҮРТГЭЛ

/мянган төгрөгөөр/

№	Байгууллага нэгжийн нэр	Аудитын төрөл	Алдаа зөрчлийн ангилал										Аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн	
			Аудитаар өгсөн зөвлөмж		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт		Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал			
			Тоо	Дүн /м.төг/	Тоо	Дүн /м.төг/	Тоо	Дүн /м.төг/	Тоо	Дүн /м.төг/	Тоо	Дүн /м.төг/	Тоо	Дүн /м.төг/
1	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Санхүү	1	8,912.50	1	1,930.19			1	13,000.00			3	23,842.7
		Нийцэл			1	135,990.30							1	135,990.3
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Санхүү	4	10,303.70	3	30,166.65	1	574.0	10	231,284.55			18	272,328.9
		Нийцэл	1	-	1	66,496.17							2	66,496.2
3	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	Санхүү	1	1,558.90	1	60,286.95			1	110,731.43			3	172,577.3
		Нийцэл	1	-	1	380,751.33							2	380,751.3
4	Орон нутгийн өмчийн газар	Санхүү							3	8,818.38			3	8,818.4
		Нийцэл	2	-									2	-
5	Худалдан авах ажиллагааны газар	Санхүү	1	1,080.00									1	1,080.0
		Нийцэл	3	35,151.90									3	35,151.9
6	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Санхүү			1	4,394.64	1	1,112.8					2	5,507.4
		Нийцэл	1	-									1	-
7	Халамжийн сан	Санхүү											-	-
		Нийцэл											-	-
8	Аймгийн Ахмадын хороо	Санхүү			1	1,260.00			1	1,530.00			2	2,790.0
		Нийцэл											-	-
9	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Санхүү											-	-
		Нийцэл											-	-
10	Чойр хотын захирагчийн ажлын алба	Санхүү	1	-					1	254.81			2	254.8
		Нийцэл											-	-
11	Сум дундын ойн анги	Санхүү			1	-	1	120.0	4	63,163.00			6	63,283.0

		Нийцэл			1	27,118.60						1	27,118.6
12	Сүмбэр сумын Засаг дарга	Санхүү	1	393,433.35	2	1,050,525.78	1	3,996.2				4	1,447,955.3
		Нийцэл										-	-
13	Шивээговь сумын Засаг дарга	Санхүү	1	2,057.60			1	1,614.5	4	265,828.86		6	269,501.0
		Нийцэл			1	32,500.00						1	32,500.0
14	Баянтал сумын Засаг дарга	Санхүү	2	9,721.35			1	2,965.5				3	12,686.9
		Нийцэл								1	-	1	-
15	Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар	Санхүү			1	1,154.25	1	1,626.2	1	768.00		3	3,548.5
		Нийцэл			1	11,880.00						1	11,880.0
16	Шивээговь сумын Засаг даргын тамгын газар	Санхүү	2	1,382.38	1	-	3	1,180.9	2	4,745.56		8	7,308.8
		Нийцэл			1	44,970.17						1	44,970.2
17	Баянтал сумын Засаг даргын тамгын газар	Санхүү			3	10,686.80	1	1,260.0				4	11,946.8
		Нийцэл			2	255,006.40					1	-	3
18	Сүмбэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Санхүү			1	3,400.00	1	500.0	1	100.00		3	4,000.0
		Нийцэл	1	-							2	-	3
19	Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Санхүү							1	2,750.00		1	2,750.0
		Нийцэл										-	-
20	Баянтал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Санхүү					1	460.0				1	460.0
		Нийцэл			1	108,025.80						1	108,025.8
21	Сүмбэр сумын Орон нутгийн хөгжлийн сан	Санхүү			2	6,735.00						2	6,735.0
		Нийцэл			1	36,893.32						1	36,893.3
22	Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сан	Санхүү			2	81,917.90	1	191.4	1	1,442,149.46		4	1,524,258.8
		Нийцэл			1	-						1	-
23	Баянтал сумын Орон нутгийн хөгжлийн сан	Санхүү			1	9,500.00						1	9,500.0
		Нийцэл			1	9,500.00					1	173,787.5	2
24	Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сан	Санхүү										-	-
		Нийцэл			1	207,501.32						1	207,501.3
25	Шивээговь сумын Хоршоо хөгжүүлэх сан	Санхүү			1	10,001.26			1	2,151.69		2	12,153.0
		Нийцэл	1	8,339.02	1	106,875.00						2	115,214.0
26	Баянтал сумын Хоршоо хөгжүүлэх сан	Санхүү							2	69,410.19		2	69,410.2
		Нийцэл									1	130,955.0	1
27	"Цөм сүргийн үржлийн төв" ОНӨҮГ	Санхүү							5	84,919.18		5	84,919.2
		Нийцэл										-	-
28		Санхүү	3	140.30					3	363,388.87		6	363,529.2

	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ	Нийцэл			2	21,903.20						2	21,903.2	
29	Талын илч ОНӨААТҮГ	Санхүү							2	74,410.26		2	74,410.3	
		Нийцэл			1	408,957.93						1	408,957.9	
30	Илчлэг-Шивээ ОНӨААТҮГ	Санхүү	3	5,347.0	1	5,991.15			4	19,160.00		8	30,498.1	
		Нийцэл			1	71,158.32						1	71,158.3	
31	УсДу ОНӨААТҮГ	Санхүү	1	7,000.0	3	31,489.62	1	2,100.0	1	189,153.50		6	229,743.1	
		Нийцэл	1	-	1	37,657.81						2	37,657.8	
32	Сүмбэр сумын Энхтүсдэм ЗГБХН өрхийн ЭМТ	Санхүү										-	-	
		Нийцэл										-	-	
	Дүн	Санхүү	21	440,937.1	26.0	1,309,440.2	15.0	17,701.5	49.0	2,947,717.8	-	-	111.0	4,715,796.5
		Нийцэл	11	43,490.92	20	1,963,185.67	0	0	0	0	6	304,742.50	37	2,311,419.09
	Бүгд дүн		32	484,428.0	46	3,272,625.9	15	17,701.5	49	2,947,717.8	6	304,742.5	148.0	7,027,215.6

Хавсралт №3

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ҮР ДҮН

№	Хөтөл - бөрийн код	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн хүрэх үр дүн		Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2025 оны зорилтот түвшин	Төсвийн гүйцэтгэлийн %	Хүрсэн түвшин	Х/Т-ний Гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн гүйцэтгэл	Үр ашиг
			1.1	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.	Хувь	2024									
1	70105	ОН-ийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	1.1	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ.	Хувь	2024	-	80	2,224,342.0	1,996,312.5	89.75%	96.0	120%	116.8%	27.0%
			1.1	Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа	Хувь	2024	90	93				90.0	97%		
2	70106	Орон нутгийн гүйцэтгэх	1.1	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.	Хувь	2024	85	88	12,603,346.0	11,246,989.9	89.24%	95.0	108%	103.5%	14.3%

		засаглалын удирдлага		Орон нутгийн бодлого удирдлага, үйл ажиллагааны хэрэгжилт, зохицуулалт, хяналт	Хувь	2024	85	90				86.0	96%		
3	71502	Хот байгуулалт, тохижилт	1.1	Ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	тоо	2024	10	14	274,590.0	259,024.5	94.33%	25.0	179%	162.6%	68.2%
				Хотын захирагчийн албаны үйл ажиллагаа	Тоо	2024	100	100				84.0	84%		
4	70426	Төрийн өмчийг хэрэгжүүлэх	1.1	Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалт, хяналтыг сайжруулна.	Хувь	2024	85	90	262,460.0	207,593.2	79.10%	98.0	109%	106.7%	27.6%
				Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаа	Хувь	2024	86.2	90				88.0	98%		
5	70418	Худалдан авах ажиллагаа	1.1	Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээг нэмэгдүүлэх	Хувь	2024	95	98	268,530.0	225,128.5	83.84%	100.0	102%	93.2%	9.3%
				Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаа	Хувь	2024	88	90				82.0	91%		
6	70417	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдлийн удирдлага	1.1	Төсөв санхүүгийн сахилга бат хөрөнгийн үр ашгийг дээшлүүлнэ.	Хувь	2024	85	100	357,260.0	351,612.3	98.42%	93.0	93%	87.7%	-10.7%
				Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа	Хувь	2024	93.33	94				89.0	95%		
7	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1.1	Байгаль орчны салбарын бодлого шийдвэрийг хэрэгжилтийг сайжруулах.	Хувь	2024	85	90	541,370.0	507,151.3	70.97%	90.0	100%	98.9%	27.9%
				Байгаль орчны газрын үйл ажиллагаа	Хувь	2024	91.9	92				91.0	99%		
				Байгаль орчны салбарын бодлого шийдвэрийг хэрэгжилтийг сайжруулах.	Хувь	2024	85	90	173,270.0	143,515.7	90.0	100%	97.6%	97.6%	

				Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө	Хувь	2024	80	85				83.0	98%		
8	71403	Ойжуулах	1.1	Сум дундын ойн ангийн үйл ажиллагаа	тоо	2024	66516	427 000	457,110.0	432,574.0	94.63%	92952.0	22%	21.0%	-73.6%
					Хувь	2024	85	91				90.3	99%		
9	71902	Нийгмийн халамж	1.1	Нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг нэмэгдүүлнэ.	тоо	2024	56	60	40,750.0	14,625.0	35.89%	26.0	43%	-40.0%	-75.9%
				Амьжиргааг сайжруулах тусламж, дэмжлэг	тоо	2024	56	60				10.0	17%		
10	71701	Биеийн тамир, спорт	1.1	Спортын төрлөөр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.	хүн	2024	3000	350 0	667,830.0	595,293.3	89.14%	2319	66%	238.0%	148.9%
				Идэвхтэй хөдөлгөөний үйлчилгээ	тоо	2024	7600	770 0				13228	172%		
				Спортын байгууллагын хэвийн үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа	тоо	2024	100	100				100	100%		
11	71602	Эрүүл мэнд	1.1	Эрүүл мэндийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа	тоо	2024	100	100	1,268,420.0	1,227,644.6	96.79%	100.0	100%	100.0%	3.2%
12	71702	Соёл урлаг	1.1	Соёлын байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах	тоо	2024	100	100	301,180.0	231,975.4	77.02%	100.0	100%	100.0%	23.0%
13	71806	Насан туршийн боловсрол	1.1	Насан туршийн боловсролын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах байр ашиглалтын үйлчилгээ	хувь	2024	100	100	5,000.0	5,000.0	100.00%	100.0	100%	100.0%	0.0%
14	71804	Мэргэжлийн боловсрол	1.1	Политехникийн коллежийн хэвийн үйл ажиллагааг хангах байр ашиглалтын үйлчилгээ	хувь	2024	100	100	765,000.0	714,806.5	93.44%	100.0	100%	100.0%	6.6%
15	71802	Ерөнхий боловсрол	1.1	Ерөнхий боловсролын сургуулийн хэвийн үйл ажиллагааг хангах	хувь	2024	100	100	1,690,080.0	1,603,640.4	94.89%	100.0	100%	100.0%	5.1%

16	71801	Сургуулийн өмнөх боловсрол	1.1	Хууль, журамд нийцүүлэн байр ашиглалтын үйлчилгээг зохион байгуулсан байна.	Хувь	2024	100	100	671,370.0	648,649.4	96.62%	100.0	100%	100.0%	3.4%
17	70801	Мал аж ахуй хөгжүүлэх	1.1	Каракуль хонины тоо, толгойг өсгөхөд чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.	Тоо	2024	13.45	80	35,768.3	35,768.1	100.00%	90	113%	125.2%	25.2%
				Каракуль хонины тоо, толгойг өсгөнө.	Тоо	2024	118	150				169	113%		
			1.2	Малын өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө	Хувь	2024	93	95	111,931.7	85,932.0	76.77%	100	105%	105.3%	28.5%
				Малын гоц халдварт өвчнийг бууруулна.	Хувь	2024	2	2.5				3	100%		
18	72208	Ахмад настны хөгжил, хамгаалал	1.1	Ахмад настны талаарх төрийн чиг үүргийг гүйцэтгэж, ахмад настанд чиглэсэн арга хэмжээний тоог нэмэгдүүлэх.	тоо	2024	25	30	135,000.0	135,000.0	100.00%	39.0	130%	139.9%	39.9%
				Ахмадын хорооны хэвийн үйл ажиллагааг хангах үйл ажиллагаа	Хувь	2024	90	91				100.0	110%		
19	71101	Автозам	1.1	Орон нутгийн авто зам, замын байгууламжийг нэмэгдүүлэн иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх.	Тоо	2024	8	5	1,098,500.0	756,895.9	68.90%	5.0	100%	66.0%	-2.9%
				Замын сангийн хөрөнгөөр хийх төсөл арга хэмжээ	Хувь	2024	100	100				66.0	66%		
20	72101	Жижиг дунд үйлдвэрлэл ийг дэмжих	1.1	Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих	сая төгрөг	2024		300	300,000.0	300,000.0	100.00%	300	100%	100.0%	0.0%
				Зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хувь	2024	100	100	908,404.7	231,755.5	25.51%	100.0	100%	100.0%	74.5%
21	72203	Хүүхдийн хөгжил, хамгаалал	1.1	Хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	тоо	2024	10	10	50,000.0	45,293.4	90.59%	16.0	160%	160.0%	69.4%

				Хүүхдийн аюулгүй байдлыг хангасан байдал	Тоо	2024	90	100				100.0	100%		
22	70503	Орон нутгийн хөрөнгө оруулалт	1.1	Орон нутгийн хөгжлийн сангаар 7 зорилт, 27 арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Тоо	2024	33	18	13,853,316.1	9,313,811.3	67.23%	16.0	89%	88.9%	21.7%
Нийт									39,064,828.8	31,315,992.7				88.3%	88.3%